

МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2010 он 01 дүгээр
сарын 27 -ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Хорооны хурлын 23 дугаар тэмдэглэлээр өгсөн үүргийн дагуу эдийн засгийн хямралт байдлыг даван туулахад брокер, дилерийн компаниудын үйл ажиллагааг дэмжих саналыг Үнэт цаасны газрын дарга Э.Ганбат сонсгож танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Саналыг авч хэлэлцээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд үүрэг болгохоор шийдвэрлэв:

1. Үнэт цаасны зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажиллаагүй компаниудад анхааруулж, зохих төлөвлөгөө гаргуулан ажиллуулах;
2. Цаашид брокер, дилер, андеррайтеруудын үйл ажиллагаа болон санхүүгийн чадавхыг сайжруулах үүднээс дүрмийн сангийн доод хэмжээг нэмэгдүүлэх талаар болон бусад шаардлагатай судалгааг хийж, саналаа танилцуулах;
3. Хариуцсан брокер, дилерийн компанигүй аймгийг хариуцсан компанитай болгох ажлыг орон нутгийн захиргаатай хамтран ажиллах болон зохих хөнгөлөлт үзүүлэх боломжтой эсэхийг нягтлан саналаа танилцуулж зохих шийдвэрийг гаргуулах замаар шийдвэрлэх.

2. Өгсөн үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар /Э.Ганбат/-д даалгав.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН